



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

13330 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
13 дугаар хороо, 14 дүгээр хороолол,
Энхтайваны өргөн чөлөө-57
Утас: 26-31-60, Факс: (976-11) 45-82-54
<http://www.bzd.ub.gov.mn>


2019.05.08 № 01а/276
танай _____-ны № _____-т

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА ТАНАА**

Нийслэлийн Засаг даргын 2019 оны “ Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дугаартай албан даалгаврыг хавсралтаар хүргүүлж байна.

Хэрэгжилтийг ханган ажиллаж, улирал бүрийн сүүлийн 7 хоногт тайланг b.boloroobolor@gmail.com хаягаар болон албан тоотоор ирүүлнэ үү.

Хавсралт..3.. хуудастай.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛИЙН
УДИРДАГЧ-ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Д.УЛАМБАЯР

D:\2019 alban\ZD. A5.doc

1130200363



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс
сэргийлэх талаар авах зарим арга
хэмжээний тухай

Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, аливаа болзошгүй осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн орчны аюулгүй байдлын стандарт, шаардлагыг мөрдүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 119 дүгээр тогтоолоор сар бүрийн 9-ний өдөр "Бидний эрүүл мэнд-Аюулгүй байдал" өдрийг зохион байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан ДААЛГАХ нь:

Нэг.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дарга нарт:

1.1.Иргэдийн эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулах;

1.2.Хүнсний бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн явцад гарах технологийн алдаа, /эгзэгтэй цэгийг аюулаас хамгаалах/ ажиллагаанд хяналт тавьж ажиллах, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, хүнсний бараа бүтээгдэхүүнийг чанарын шаардлагад нийцүүлэх;

1.3.Хүүхдийн насны онцлогт тохирсон эрүүл, зөв хооллолт, өвчин эмгэг болон осол гэмтэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргаж эцэг, эхчүүдэд ухуулан таниулах;

1.4.Хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, өсвөр насны хүүхэд, залуусыг архи, согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодис болон цахим орчинд донтох эрсдэлээс сэргийлэх;

1.5.Нийслэлд гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдарч байгаа иргэд, насанд хүрээгүй хараа хяналтгүй хүүхдүүдийг өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөж байгаа хүүхдүүдийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах;

1.6.Өсвөр үе, залууст гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, хүсээгүй жирэмслэлт болон бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх сургалт, сурталчилгааг явуулах;

111020000014

1.7.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дотоод, гадаад орчин, биеийн тамирын талбай, хүүхэд тоглуулах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын техник, хэрэгслийн аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

1.8.Сургуулийн орчимд насанд хүрэгчдэд зориулсан үйл ажиллагаа явуулдаг үйлчилгээний газрууд /дэн буудал, зочид буудал, цэнгээний газар, тоглоомын газар/ үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохгүй байх, үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авч хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;

1.9.Хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрүүл мэнд, боловсролын болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авах, ажлын байрны дэг журмыг сахиулах, хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үүрэг хариуцлагыг өндөржүүлж ажиллах;

1.10.Замын хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй зорчих, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын тэмдэг, тэмдэглэгээ, гарц, гэрлэн дохио, камерын тоог нэмэгдүүлэх;

1.11.Нийтийн эзэмшлийн зам талбайн орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг зохион байгуулах;

1.12.Эрчим хүч, шугам сүлжээ, инженерийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ажилтан, албан хаагчдыг хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар мөрдүүлэх, болзошгүй үйлдвэрлэлийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх;

1.13.Хүн амын ундны усны чанар, аюулгүй байдлыг хангах, ундны усны эх үүсвэрийн орчимд иргэдийг суурьшуулахгүй байх, зөвшөөрөлгүй оршин сууж буй иргэдийг албадан нүүлгэх арга хэмжээг зохион байгуулах;

1.14.Хог хаягдал, гэр хорооллын нүхэн жорлонгийн бохиросоос үүдэх хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр иргэд олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, нүхэн жорлон, угаадасны нүхний стандартыг мөрдүүлэх;

1.15.Гал түймрээс урьдчилан сэргийлэх, угаартах, хордох, хөлдөх гэх мэт гэнэтийн аюул осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг явуулах;

1.16.Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр "Завьт эргүүл" арга хэмжээг зохион байгуулах;

1.17.Нийтийн тээврийн үйлчилгээнд иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлж, эрүүл ахуйн болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, холбогдох стандарт шаардлагыг хангуулах;

2.Хоёр. Аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад:

2.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага бүр өөрийн байгууллагын ойр орчмын 50 метр орчим газрын тохижилт, аюулгүй байдлыг хангах;

2.2.Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл, ахуйн стандартыг чанд мөрдөх, албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах, мэдээллээр хангаж ажиллах;

2.3.Ажилтан албан хаагчдад эрүүл зан үйл төлөвшүүлэх, зөв дадлыг бий болгох чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмол явуулах;

2.4.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд "Бидний эрүүл мэнд-Аюулгүй байдал" сэдвийн дор тодорхой ажлыг зохион байгуулж байх.

Гурав. Иргэд олон нийт, эцэг эх, асран хамгаалагч нарт:

3.1.Бага насны хүүхдийг гэрт нь харгалзах хүнгүйгээр орхихгүй байх, хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах;


3.2.Монгол гэрт амьдардаг бол гэрийн доторлогоог галд тэсвэртэй материалаар өөрчлөх, халуун тогооны аюулгүй хамгаалалт, залгуурын бэхэлгээ, цахилгаан хэрэгслийн хамгаалалт, цахилгааны монтажийг стандарт шаардлагад нийцүүлэн хийх гэх мэт гэр орныхоо аюулгүй байдлыг хангах;

3.3.Хараа хяналт сул, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй болон өртөж буй хүүхдийг холбогдох төрийн байгууллагад шуурхай мэдээлэх, шаардлагатай үед яаралтай тусламж үзүүлэх зэргээр иргэний үүргээ биелүүлэх.

4.Дээрх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлаа иргэд олон нийтэд сурталчлан таниулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон улирал бүрийн эхний 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст ирүүлж байхыг даалгасугай.

5.Албан даалгаврын хэрэгжилтэд хариуцсан чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч нарт тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН